



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№147 /361/

2022.08.19

Цаг үе, үйл явдал

АГААРЫН ДОВТОЛГООНООС ХАМГААЛАХ ЦЭРГИЙН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалаас Монгол Улсад Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг үүсэж хөгжсөний түүхт 58 жилийн ойг угтан харьяа анги, салбаруудынхаа дунд 2022 оны эхний хагас жилд үндсэн үүргийн биелэлт, цэргийн алба, сахилга зохион байгуулалт, сургалт бэлтгэл зэргээр тэргүүний салбарыг шалгарууллаа.

Мөн энэхүү ойн арга хэмжээний хүрээнд Агаарын цэрэгт олон жил үр бүтээлтэй ажилласан Улсыг агаарын довтолгооноос хамгаалахын цэргийн байлдааны сөнөөгч онгоцны 1 дүгээр

зэргийн нисгэгч, гавьяат нисгэгч, чөлөөнд байгаа дэд хурандаа С.Шаравсамбууг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн тушаалаар "Агаарын цэргийн хүндэт тэмдэг"-ээр шагналаа.

Түүнчлэн Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа хошууч А.Сүрэнхүү захирагчтай 104 дүгээр тусгай рот 2021-2022 оны сургуулийн жилийн эхний хагас жилийн дүнгээр тэргүүлж Агаарын цэргийн командлалын дурсамж, үнэ бүхий зүйлийн эзэд боллоо.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 18	☁️ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 27	☁️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.207.00	3.213.0
EUR 🇪🇺	3.250.0	3.280.0
CNY 🇨🇳	473	476
RUB 🇷🇺	49.80	50.20
JPY 🇯🇵	23.60	23.90
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.08.19 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 23

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ЗУРГААН ЦАГААН ХӨХ ЛУУ ӨДӨР

Үс засуулбал:

Эд эдлэл, идээ ундаа олдono
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.52-19.59

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Мунхрахуй

Суудал: Ус

Энэ өдөр хулгана, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй.

Эл өдөр гэмтнийг шийтгэх, угаал үйлдэх, бороо хур оруулах, зэтгэрийг номхотгох, хөгжмийн зэмсэг урлахад сайн. Гүүр тавих, газар ухах, гөлөг тэжээхэд муу. Өдрийн сайн цаг нь бар луу, могой, бич, тахиа, гахай болой.

Хол газраар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд, эдлэл, идээ ундаа олно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 599,124,406

Эдгэрсэн

Нийт: 573,111,944

Нас барсан

Нийт: 6,466,793

"АРАВТ-2022" МОРИН ЦЭРГИЙН УРАЛДААНД МОНГОЛЧУУД АВАРГАЛЛАА

"Олон улсын цэргийн наадам"-ын хүрээнд зохион байгуулдаг "Аравт" морин цэргийн уралдаан амжилттай явагдаж өчигдөр буюу энэ сарын 18-ны өдөр өндөрлөлөө.

Энэ жилийн "Аравт" тэмцээнд манай улсаас гадна ОХУ, Узбекистан, Зимбабве гэсэн дөрвөн орны 40 гаруй тамирчин Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийн тусгайлан төхөөрөмжилсөн районд цаг уурын хүндрэлтэй нөхцөлд богинын болон уртын зайн маршийг үйлдэж хурд, хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн юм.

"Аравт-2022" морин цэргийн уралдааны тэргүүн байрт Монгол Улсын Зэвсэгт хүчний баг тамирчид шалгарч, шилжин явах цомын эзэд болсон бол дэд байрыг Узбекистан, ОХУ, гутгаар байрыг Бүгд Найрамдах Зимбабве Улсын баг тамирчид эзэллээ. Мөн уралдааны үеэр шилдэг номинацуудыг шалгаруулсан ба "Тэргүүний тасгийн захирагч"-аар ОХУ-ын тасгийн захирагч, сонсогч Ш.К.Леонидович, "Тэргүүний сапёрчин"-аар Монгол



Улсын багийн тамирчин, ахлагч С.Билэгт, "Тэргүүний мэргэн буудагч"-аар Бүгд Найрамдах Зимбабве Улсын тамирчин, байлдагч Рэза, "Морины анд нөхөр"-өөр Узбекистан Улсын багийн тамирчин, байлдагч Уралов нар шалгарч бусад нөхдөө манлайлав.


Тус уралдааны хаалтын ёслолын ажиллагаанд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, БХЯ-ны ГХАГ-ын дарга хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга бригадын генерал Г.Болор, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат болон манай улсад суугаа

Элчин сайдын яамны Батлан хамгаалахын атташе, дипломат ажилтнууд оролцож шагналыг нь гардуулан баяр хүргэлээ.

Мөн уралдааныг амжилттай зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн захирагч хурандаа Н.Мягмарцоож, 311 дүгээр ангийн захирагч хурандаа Ц.Буянжаргал, Бүгд Найрамдах Зимбабве Улсын багийн ахлагч хошууч Жосеп Кумбрай Муронза нарыг "Биеийн тамир-Алдар" медалиар шагнасан юм.



"Байгууллагын соёл гэж юу вэ?" сэдэвт таниулах сургалтийг зохион байгууллаа



Зэвсэгт хүчний 015 дугаар анги

"Нийгмийн ардчилал залуучуудын академ"-ийн сургагч багш Н.Гантогтохтой хамтран "Байгууллагын соёл гэж юу вэ, байгууллагын үнэ цэн" сэдэвт хичээлийг зохион байгууллаа.

Байгууллагын соёлыг тодорхойлогч хүчин зүйлүүд, байгууллага хэрхэн ямар өнцгөөр харах, хандлага хэрхэн өөрчлөх вэ зэрэг сонирхолтой сэдвүүдээр яриа өрнүүлсэн нь алба хаагчдын оролцох оролцоог илүү

нэмэгдүүлсэн бөгөөд байгууллагын соёл зөвхөн даалгавар, дүрэм журам, тоо баримтын асуудлын хүрээнд оршин тогтнодоггүй.

Хамт олны бүтээлч байдал, нэгдмэл ажиллагаанаас үүдэлтэйг алба хаагчдад таниулснаар ажиллах урам зоригийг нь сэргээсэн үр өгөөжтэй сургалт болж өндөрлөжээ.


Ахлагч Б.Золзаяа

Бидний бахархал

ТАМИРЧИН БҮСГҮЙ



Тогоосүрэн овогтой ахлагч Буяннэмэх нь 1997.08.08-нд Улаанбаатар хотод төрсөн. 2015-2016 онд УБХИС-ийн Ахлагчийн сургуулийг



радио телеграфчин мэргэжлээр төгсөн, Зэвсэгт хүчний 013 ангид томилогдон ажиллаж байна. Түүний гаргасан амжилтуудаас

дурдвал 2016 онд Р.Гаваа агсны нэрэмжит "Хурдач радист" тэмцээнд нэгдүгээр байр, алтан медаль, өргөмжлөл, шилжин явах цом.

2017 онд "Сургуулийн үүрэг гүйцэтгэх төрөл"-д нэгдүгээр байр, алтан медаль, Зэвсэгт хүчний "Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн"-д амжилттай оролцож тусгай байр, Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит "Марш тактик, тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээн"-д амжилттай оролцож, гуравдугаар байр, "Радио телеграфчин" зэрэг хамгаалах шалгалтад амжилттай оролцож, хоёрдугаар зэрэг хамгаалжээ.

2019 онд Зэвсэгт хүчний "Армийн аварга шалгаруулах гимнастикийн тэмцээн"-д амжилттай оролцож алтан медаль.

2021 онд Зэвсэгт хүчний "Армийн аварга шалгаруулах гардан тулааны тэмцээн"-д амжилттай оролцож мөнгөн медаль тус, тус хүртсэн байна.

2008 оноос одоог хүртэл Таеквондогийн спортоор хичээллэж байгаа бөгөөд "Мөнх хөх сүлд" клубийн ууган тамирчин, олон улсын хэмжээний мастер, биеийн

тамир спортын тэргүүний ажилтан түүний тив, дэлхийд Монголынхоо нэрийг гаргасан амжилтуудыг танилцуулж байна.

-Олон Улсын Таеквон-Догийн Дэлхийн аваргын мөнгө, хошой хүрэл медаль

-Ази тивийн аварга, мөнгө, хүрэл медаль

-Олон улсын тэмцээний 4 удаагийн аварга

-Улсын аварга шалгаруулах тэмцээний 10 удаагийн аварга, 3 мөнгө, 7 хүрэл медаль

-Улсын 4 удаагийн шилдэг эмэгтэй тамирчин

-Олон улсын Таеквондогийн Монголын холбооны шигшээ багийн тамирчин, хар бүс I дантай.

-Монголын Таеквондогийн холбооны шүүгч юм.

Үнэхээр бахархахгүй байхын аргагүй тамирчин бүсгүйдээ Зэвсэгт хүчний бүх эмэгтэй дайчдаас нь халуун баяр хүргэе. Ийм мундаг бүсгүйдэй хамт ажиллаж байгаа бид бүхэн азтай.



Ахлах ахлагч Н.Ууганцэцэг

Цахим шууданд

"Амьд гарах арга ухаан"-ы сургагч багшийн анхан шатны дамжааг зохион байгууллаа



2021-2022 оны цэргийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөө, ТХЦК-ийн сургалт бэлтгэлийн зааврын дагуу Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн материаллаг бааз сургагч багш нарыг түшиглэн Тусгай хүчний цэргийн командлалын харьяа ангиудын бие бүрэлдэхүүнүүдийг "Амьд гарах ухааны анхан шатны дамжаа"-нд хамруулж байна.

Сургалтаар тусгай хүчний бие бүрэлдэхүүний эзэмшвэл зохих ур чадварын шаардлага, шалгуурыг хангах Амьдрах чадвар, сэтгэл зүйн бэлтгэл, амь дүйсэн мөчийг тэсвэрлэн гарах арга ухаанд сургах, газар орон, байгаль, цаг уурын онцгой хүнд нөхцөлийг даван туулах, дасан зохицох, өөрийн болон

нөхрийн амь нас, эрүүл мэндийг халдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж, аюулгүй байдлаа хангаж сурах юм. Ингэснээр ямар ч хүнд нөхцөлд өгөгдсөн үүргийг алдаа мадаггүй биелүүлэх чадварт суралцана.

Зэвсэгт хүчний 150 дугаар анги ахлах ахлагч Б.Ёндон



Таны сонорт

ЭЦЭГ ХҮНИЙ НУЛИМС

Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн Хүндэт харуулын тусгай ротын байлдагч Б.ЗОЛБЯАР

*Будант дэлхийн жам ёсоор
Бяцхан үр минь мэндэллээ
Буурал орчлонгийн тавиланг дагаж
Би өнөөдөр аав боллоо*

*Эцэс төгсгөлгүй хорвоод
Эцэг хүний жаргалыг эдлээ
Эхэлсэн жаргал дуусдагийг санаж
Энэ үедээ гацахыг хүснэ*

*Хүү минь өнөөдөр хэлд орлоо
Хүмүүн болсны анхны үг нь аав байлаа
Аав гэх гуравхан үсэг нь
Аугаа орчлон тэр чигээрээ багтдагийг ухаарлаа*

*Үргэлжлэх үр минь намайг
Алтайн сүрлэг нуруудтай зүйрлэнэ
Үнэн хэрэгтээ миний бие
Аавынхаа үргэлжлэл хүү юм сан*

*Өмөлзөх зүрхнийхээ угааа
Өөрийгөө би зэмлэнэ
Өхөөрдөм үр минь
Өөдөөс минь харж инээмсэглэнэ*

*Эр хүний нулимс
Энэ ертөнцийг ариутгах гашуун
Эцэг хүний нулимсыг
Энэ яваа насандаа үзэхгүй гэдэг*



Фото агшин

